Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2 (цаашид "Төсөл" гэх)-ын санхүүгийн тайлан нь Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс ("УСНББОУСЗ") гаргасан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартууд ("УСНББОУС"), Төслийн гэрээ, Төслийн удирдлагын гарын авлагад тусгагдсан санхүү нягтлан бодох бүртгэлийн холбогдох заалтууд, Азийн хөгжлийн банкны нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу бэлтгэгдсэн болно. Тус Төслийн Удирдлага нь 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн хугацаан дахь Төслийн санхүүгийн байдлын тайлан, ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, тусгай дансны мөнгөн гүйлгээний тайлан, зарцуулалтын тайлан, нөхөн дүүргэлтийн тайланг уг өдрийн байдлаар үнэн зөв тусгасан эсэх баталгааг хариуцна.

Удирдлагын үүрэг нь төслийн санхүүгийн байдлыг үнэн зөв илэрхийлж чадах, зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтлөх бөгөөд санхүүгийн тайлангууд нь тодруулга 2-т дурдсан шаардлагуудад нийцсэн байхыг баталгаажуулах явдал болно.

Төслийн мөнгө, эд хөрөнгийг хадгалан хамгаалах, тэдгээрийг аливаа заль мэх, хэвийн бус үйлдлээс сэргийлэх, эдгээр үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь төслийн удирдлагын үүрэг юм.

Удирдлага нь 5-8 болон 13-24 дугаар хуудас дахь санхүүгийн тайлангууд болон тодруулгуудыг үндэслэлтэй, зохистой дүн шинжилгээ болон тооцоогоор баримтжуулсан, тууштай мөрдөгддөг нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг ашиглан бэлдсэн бөгөөд нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартуудыг дагаж мөрдсөн гэж үзэж байна.

Төслийн удирдлагын шийдвэрийн дагуу гарын үсэг зурсан:

Ц.Болормаа  
Төслийн зохицуулагч

НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН  
ТӨСӨЛ 2

С.Оюунцэцэг  
Төслийн санхүүгийн ажилтан

Улаанбаатар, Монгол Улс

Огноо: 2023.05.16

2000000120



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын удирдлагад

### Дүгнэлт

Бид Цар Тахлын Үед Хариу Аргаа Хэмжээ Авх Нийгмийн Хамгааллын Төсөл 2 (“Төсөл”)-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдлын тайлан, ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, тусгай дансны мөнгөн гүйлгээний тайлан, зарцуулалтын тайлан, нөхөн дүүргэлтийн тайлан, болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланда аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг байдлын хувьд Төслийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, тухайн жилийн санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“УСНББОУС3”)-өөс гаргасан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (“УСНББОУС”)-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Нягтлан бодогчдын олон улсын холбоо, Аудит ба Баталгаажуулалтын Стандартын Зөвлөл (АБОУС3)-өөс гаргасан Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-үүдүн дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НБЁЗОУС3”)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм (“МНБЁЗД”)-д дурдсан санхүүгийн тайлангийн аудитад хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу төслөөс хараат бус байж дээрх шаардлагад тодорхойлсон ёс зүйн бусад шаардлагыг даган биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангальтай бөгөөд тохиromжтой гэж итгэж байна.

### Бусад асуудал

Төслийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд “Эйч Эл Би Монголия” ХХК аудит хийсэн бөгөөд 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдөр эдгээр тайлангуудад аудитын Зөрчилгүй санал дүгнэлт өгсөн болно.

### Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Төслийн удирдлага нь Санхүүгийн тайлангуудыг УСНББОУС -ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг дүнг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.



# Эйч Эл Би Монголия Аудит ХХК

Зөвлөх Үйлчилгээ ба Аудит, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Сүлжээ

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын Гүйцэтгэх Удирдлагад (үргэлжлэл)

### Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг хэмжээний алдаатайд тооцогдоно.

Нягтлан бодогчдын олон улсын холбооны вэб хуудсанд байршуулсан АОУС 700-ийн 38-аас 39-р зүйлийн (шинэчлэн найруулсан) дагуу хийх аудитын ажлын үед бид мэргэжлийн үнэлээмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримталсан.

## ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК



Чүлтэмдоржийн Энхтуяа, Партер

Монгол улс, Улаанбаатар хот,  
Хан-Уул дүүрэг, 1-р хороо,  
Чингисийн өргөн чөлөө 8-1,  
Мөнх Тауэр оффис, 505/505A тоот

Огноо: 2023 оны 5-р сарын 16

**2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

	Тод	2022 ам.доллар	2021 ам.доллар
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө ба мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3	425,652.54	443,956.73
Дансны авлага	4	50.22	19.66
Урьдчилгаа	5	753,845.77	-
Бараа материал	6	676.54	231.52
<b>Нийт эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>1,180,225.08</b>	<b>444,207.91</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө		-	-
Биет бус хөрөнгө		-	-
<b>Нийт эргэлтийн бус хөрөнгө</b>		<b>-</b>	<b>-</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1,180,225.08</b>	<b>444,207.91</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Өглөг	7	31.11	19.66
<b>Нийт bogino хугацаат өр төлбөр</b>		<b>31.11</b>	<b>19.66</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Урт хугацаат зээл	8	68,720,834.48	42,225,870.23
<b>Нийт урт хугацаат өр төлбөр</b>		<b>68,720,834.48</b>	<b>42,225,870.23</b>
<b>Нийт өр төлбөр</b>		<b>68,720,865.59</b>	<b>42,225,889.89</b>
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>			
Өмнөх оны үр дүн		(41,781,681.98)	-
Тайлант оны үр дүн		(25,758,958.53)	(41,781,681.98)
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ</b>		<b>(67,540,640.51)</b>	<b>(41,781,681.98)</b>
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР</b>		<b>1,180,225.08</b>	<b>444,207.91</b>

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.*

**2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

	Тод	2022 ам.доллар	2021 ам.доллар
<b>Орлого</b>			
АХБ-ны санхүүжилтийн орлого		-	-
Монгол улсын Засгийн газрын эх үүсвэр	10	103,847.08	-
Хүү амлалтын шимтгэл			-
Тендерийн орлого		64.09	-
Бусад орлого		-	-
<b>Орлогын дүн</b>		<b>103,911.17</b>	-
<b>Зардал</b>			
<b>Хөрөнгө оруулалтын зардал</b>			
Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн мөнгөн тэтгэмж	9	25,039,021.80	41,743,390.23
Бараа, үйлчилгээ	10	103,847.08	
Зөвлөх үйлчилгээ	11	154,969.58	
Төслийн удирдлага /цалин НДШ/	12	63,830.34	32,126.22
Ургал зардал	13	6,762.26	2,660.53
Аудитын үйлчилгээний зардал	13	6,357.21	
Санхүүгийн зардал	14	488,055.52	3,480.00
Банкны шимтгэл	15	25.00	25.00
<b>Зардлын дүн</b>		<b>25,862,868.79</b>	<b>41,781,681.98</b>
<b>НИЙТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>		<b>(25,758,957.61)</b>	<b>(41,781,681.98)</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОЛЗ/(ГАРЗ)</b>			
Ханшийн тэгшитгэлийн олз/(гарз)		(0.92)	-
<b>НИЙТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОЛЗ/(ГАРЗ)</b>		<b>(0.92)</b>	-
<b>Тайлант үеийн үр дүн</b>		<b>(25,758,958.53)</b>	<b>(41,781,681.98)</b>

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.*

**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН  
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Тод	Засгийн газрын хувь оролцоо	Бусад ам.доллар	Тайлант үеийн үр дүн ам.доллар	Хувьцаагаарх мөнгө ам.доллар	Нийт цэвэр хөрөнгө/өмч ам.доллар
	ам.доллар				
<b>2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар</b>	-	-	-	-	-
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, залруулга	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(41,781,681.98)	-	(41,781,681.98)
<b>2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар</b>	-	-	(41,781,681.98)	-	(41,781,681.98)
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, залруулга	-	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(25,758,958.53)	-	(25,758,958.53)
<b>2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар</b>	-	-	(67,540,640.51)	(67,540,640.51)	

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.*

**2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН  
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

	Тод	2022 ам.доллар	2021 ам.доллар
<b>Үзүүлэлт</b>			
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
<b>Мөнгөн орлого</b>			
АХБ-ны санхүүжилт		-	-
Хүлээн авсан хүү		-	-
Бусад мөнгөн орлого	148.11		-
<b>Нийт мөнгөн орлогын дүн</b>	<u>148.11</u>		-
<b>Мөнгөн зарлага</b>			
Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн мөнгөн тэтгэмж	25,039,021.80	41,743,390.23	
Бараа, үйлчилгээ	753,845.77		
Зөвлөх үйлчилгээ	154,969.58		
Ажилчдтай холбоотой зардал	63,934.39	32,126.22	
Ургал зардал	7,207.28	2,892.05	
Мэргэжлийн үйлчилгээний зардал	6,357.21		
Банкны шимтгэл	-		-
<b>Нийт мөнгөн зарлагын дүн</b>	<u>26,025,336.03</u>	<u>41,778,408.50</u>	
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<u>(26,025,187.92)</u>	<u>(41,778,408.50)</u>	
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
Үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн төлбөр		-	-
Биет бус хөрөнгө худалдан авахад төлсөн төлбөр		-	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>			
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
Хүлээн авсан зээл	26,006,883.73	42,222,365.23	
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<u>26,006,883.73</u>	<u>42,222,365.23</u>	
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг/(алдагдал)	-		-
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	(18,304.19)	443,956.73	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	443,956.73		-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	425,652.54	443,956.73	

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.*



## ХАРААТ БУС АУДИТОРЫН БАТАЛГААЖУУЛАХ АЖЛЫН ТАЙЛАН

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын үдирдлагад

### Хамрах хүрээ

Бид Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын АХБ-нд ирүүлсэн Зарцуулалтын тайлан, Нөхөн дүүргэлтийн тайлан, Тусгай дансны тайланд 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар дор дурдсан шалгуур үзүүлэлтийг бүхий л материаллаг байдлаар нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлт гаргах үндэслэлээр баталгаажуулах гэрээт ажлыг хийж гүйцэтгэлээ.

### Агуулга

Баталгаажуулалтын гол агуулга:

- Тусгай дансны горимтой холбогдуулан Төслийн санхүүгийн тайлан (Санхүүгийн тайлан), Зарцуулалтын тайлан, Нөхөн дүүргэлтийн тайлангийн талаар дүгнэлт гаргах
- АХБ-ны зээлийн үйл явцыг гэрээний дагуу ашиглаж байгаа эсэхийг баталгаажуулах.

### Шалгуур үзүүлэлтүүд

Баталгаажуулах гэрээт ажлыг гүйцэтгэхдээ доорх шалгуур, бусад асуудлыг үндэслэн дүгнэлтээ илэрхийлсэн. Үүнд:

- Төлбөрийг Зээлийн гэрээний нөхцөл болон холбогдох төслийн зааварчилгааны дагуу Урьдчилгаа данснаас хийсэн байх. Шаардлагагүй/Зохисгүй зардлыг тодорхойлсон тохиолдолд тэдгээрийг тусад нь тодруулсан байх.
- Урьдчилгаа дансыг Зээлийн гэрээний нөхцөл болон төслийн зааварчилгааны дагуу хөтөлсөн байх. Үлдэгдлээс үүссэн хүүний орлого мөн хамаарна.
- Зарцуулалтын тайланг Нөхөн дүүргэлтийн тайланд үндэслэн бэлтгэсэн байх. АХБ-д ба нягтлан бодох бүртгэлийн бүртгэлд ирүүлсэн Зарцуулалтын тайлан болон Нөхөн дүүргэлтийн тайлан хоёрын хооронд тодорхой уялдаа холбоо байх
- Зардал нь найдвартай уялдаа холбоотой баримт бичгээр нотлогдсон байх.
- Бараа, үйлчилгээг Зээлийн гэрээ болон төслийн зааварчилгааны дагуу худалдан авсан байх.
- ТХН-ийн дотоод систем, хяналтанд тодорхой дутагдал, доголдолгүй байх.

### Үдирдлагын үүрэг хариуцлага

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын үдирдлага нь 2021 оны 5 дугаар сарын 28-нд АХБ, Сангийн яамны хооронд байгуулсан Зээлийн гэрээний Санхүүгийн тайлангийн заалтын дагуу Санхүүгийн тайланг бэлтгэн, үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

### Бидний Хараат бус байдал

Бид Олон Улсын Ёс Зүйн Стандартын Зөвлөлөөс гаргасан Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрмийн дагуу ёс зүйн шаардлага, мэргэжлийн стандарт, холбогдох хууль, болон эрх зүйн шаардлагыг даган мөрдөж бүхий л талаар баримтжуулсан бодлого, журмыг оруулсан болно.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН БАТАЛГААЖУУЛАХ АЖЛЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын үдирдлагад (үргэлжлэл)

### Бидний Үүрэг Хариуцлага

Бидний үүрэг хариуцлага нь энэхүү тайланд тусгагдсан агуулгын хүрээнд шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаад баталгаажуулах ажлын дүгнэлт өгөх явдал юм. Бид баталгаажуулах гэрээт ажлыг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооны дэргэдэх Олон Улсын Аудит болон Баталгаажуулах Ажлын Стандартын Хорооноос баталсан Баталгаажуулах Ажлын Олон Улсын Стандартын дагуу төлөвлөж гүйцэтгэсэн бөгөөд онцгойлон баталгаажуулах ажлын Олон улсын стандарт 3000-д нийцүүлсэн болно.

### Баталгаажуулалтын түвшин

Баталгаажуулалтын гэрээт ажил нь асуулга явуулах, дүн шинжилгээ хийх, хяналтын тест болон бусад нотлох баримт цуглуулах горимуудаас бүрдэх бөгөөд энэ нь зөрчилгүй дүгнэлтийн үндэс гаргахад хангалттай болно. Горимууд нь залилан эсвэл алдаанаас үссэн мэдээллийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэл зэрэг шалгагч аудиторын мэргэжлийн шийдлээс хамаарна. Бидний цуглуулсан нотлох баримт нь зохих үндэслэл гаргахад хангалттай гэж дүгнэж байна.

### Гүйцэтгэсэн ажлын хураангуй

Бид дараах горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд үүгээр хязгаарлагдаагүй. Үүнд:

- АХБ-аас тогтоосон бодлого, журмыг хянах;
- АХБ- аас тогтоосон бодлого, журамд гарсан аливаа өөрчлөлтийг хянах;
- Зарцуулалтын зөвшөөрөл/баталгаа болон үндэслэлийг холбогдох дэмжих баримтуудтай хянах;
- Зардлын хуваарилалтыг тохирсон төсөвт нийцүүлсэн байдлыг хянах;
- Дансны арифметик нарийвчилсан тооцооллыг шалгах, баримт бичиг болон санхүүгийн тайланг хянах;
- Төслийн болон санхүүгийн нягтлан бодох бүртгэл, тайлангийн үйл ажиллагааны үр ашигтай байдлыг батлах.
- Төслийн бараа материалын бодит байдал, хөдөлгөөнийг шалгах (үндсэн хөрөнгө, бараа материал, эргэлтийн хөрөнгө);
- Санхүүгийн баримт бүртгэл болон данс хөтлөлтийг хянах;
- Холбогдох гэрээнд заасны дагуу хөрөнгийн заалт, хөрөнгийг зөвхөн зориулалтын дагуу ашиглаж байгааг шалгах
- Гадны санхүүжилтийн ашиглалт нь холбогдох хууль болон санхүүжилтийн гэрээнд нийцэж байгаа эсэхийг шалгах;
- Урьдчилгаа санхүүжилтийг шалгахдаа дараах зүйлсийг баталгаажуулах зорилгоор төлөвлөж, гүйцэтгэсэн. Үүнд:
  - a) АХБ-ны Зээлийн зарцуулалтын гарын авлагад заасны дагуу Урьдчилгаа данс (болон бусад дэд дансууд) хөтлөгдсөн байх.
  - b) Урьдчилгаа дансны (болон бусад дэд дансны) бэлэн мөнгөний үлдэгдэлийг баримтаар баталгаажуулсан байх.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН БАТАЛГААЖУУЛАХ АЖЛЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын удирдлагад (үргэлжлэл)

### Гүйцэтгэсэн ажлын хураангуй (үргэлжлэл)

- c) Урьдчилгаа данснаас (болон бусад дэд данснаас) гарсан зардлууд нь Зээлийн болон томоохон гэрээнд заасан хуваарилалтын дагуу мөрдөгдсөн байх.
- Зардлыг нөхөн төлүүлэх, урьдчилгаа дансанд олгосон урьдчилгаа төлбөрийг барагдуулах тухай зардлын хураангуйд заасан холбогдох баримт бичиг хөтлөх;
- Зардлын хураангуй (ЗХ) тайлан бэлтгэх дээр аудитийн төлөвлөгөө болон үйл ажиллагаа дараах байдлаар хийгдсэн
  - a) АХБ-ны Зээлийн зарцуулалтын гарын авлагад заасны дагуу ЗХ-д бэлтгэгдсэн
  - b) ЗХ-д тусгагдсан зардлын бие даасан төлбөрүүд нь баримтаар баталгаажсан байх
  - c) ЗХ-д тусгагдсан зардал нь Зээлийн болон Томоохон гэрээнд заасан төсвийн зорилго болон зарцуулалтын журмыг мөрдсөн байх.
  - d) ЗХ-д тусгагдсан зардлын хэмжээ нь Зээлийн болон томоохон гэрээнд заасан хуваарилалтын хувийн дагуу хийгдсэн байх.
- Зохих тендер, бараа материал болон үйлчилгээний худалдан авалт, гэрээний дагуу худалдан авалт хийх журам байгаа эсэхийг хянах;
- Санхүүгийн хяналтын өмнөх тайлангаас гарсан ажиглалт, тохируулга, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах;
- Дотоод систем болон үйл явц нь журмын дагуу явж буй эсэх, түүнтэй холбоотой баримт бичиг авах, түүнчлэн;
- Худалдан авах ажиллагааг хянах дотоод хяналтын сүл талыг баталгаажуулах.

Эдгээр горимыг асуулга явуулах, ажлын зураг авалт гүйцэтгэх, баримт шалгах, шинжилгээний горим гүйцэтгэх, тайлагнах бодлогын зохистой байдлыг үнэлэх, тулган баталгаажуулах зэрэг мэргэжлийн шийдэлд тулгуурлан гүйцэтгэсэн.

### Бидний баталгаажуулалтын хязгаарлалт

Гэрээт ажлын хүрээнд энэхүү Хараат бус Санхүүгийн тайлангийн Баталгаажуулалтын тайлан нь зөвхөн АХБ-д зориулагдсан бөгөөд өөр ямар ч зорилгоор ашиглагдахгүй байна.



# ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК

Зөвлөх Үйлчилгээ ба Аудит, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Сүлжээ

## ХАРААТ БУС АУДИТОРЫН БАТАЛГААЖУУЛАХ АЖЛЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын удирдлагад (үргэлжлэл)

### Дүгнэлт

Бидний үзэж байгаагаар 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарх Нөхөн дүүргэлтийн тайлан нь Тусгай Дансны журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2 нь бүх материаллаг зүйлсийн хувьд 2021 оны 05 дугаар сарын 28-ний өдрийн Зээлийн гэрээнд заасны дагуу үнэн зөв, зохистой ашиглаж ирсэн.

Тусгай дансны тайлан нь бүх материаллаг зүйлсийн хувьд 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн эцсийн үлдэгдлээр болон 2022 оны 12-р сарын 31-ний дансны үйл ажиллагаанд үнэн зөв толилуулсан.

Бүх зардлууд нь үнэн зөв, холбогдох бичиг баримт дээр түлгуурлагдсан.

## ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК



Чүлтэмдоржийн Энхтуяа, Партнер

Монгол улс, Улаанбаатар хот,  
Хан-Уул дүүрэг, 1-р хороо,  
Чингисийн өргөн чөлөө 8-1,  
Мөнх Тауэр оффис, 505/505A тоот

Огноо: 2023 оны 5-р сарын 16

**2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН  
АУДИТЛАГДСАН САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН**

	31/12/2022-НИЙ хуримтлагдсан дүн ам.доллар	Тайлант он ам.доллар	31/12/2021-НИЙ хуримтлагдсан дүн ам.доллар
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		445,956.73	
<b>Санхүүжилтийн эх үүсвэр</b>			
<b>Нийт санхүүжилт</b>	298,635,053.04	44,387,979.46	254,247,073.58
АХБ-ны зээлийн санхүүжилт -L4051	26,463,161.61	4,333,752.74	22,129,408.87
АХБ-ны зээлийн санхүүжилт -L4052	42,257,672.87	22,161,211.51	20,096,461.36
МУЗГ-ын санхүүжилт	229,914,218.56	17,893,015.21	212,021,203.35
<b>Нийт бусад орлого</b>	64.09	64.09	-
Хүүгийн орлого	-	-	-
Бусад орлого-Тендерийн орлого	64.09	64.09	-
<b>Нийт санхүүжилтийн эх үүсвэр</b>	<b>298,635,117.13</b>	<b>44,388,043.55</b>	<b>254,247,073.58</b>
<b>Зарцуулалт</b>			
<b>АХБ-ны санхүүжилт</b>			
CMP мөнгөн тусlamж-L4051	26,223,161.61	4,093,752.74	22,129,408.87
CMP мөнгөн тусlamж-L4052	40,559,250.42	20,945,269.06	19,613,981.36
Бараа	753,845.77	753,845.77	-
Зөвлөх үйлчилгээ	154,969.58	154,969.58	-
Төслийн үйл ажиллагааны зардал	112,433.12	77,414.86	35,018.27
Хүү-L4051	240,000.00	240,000.00	-
Хүү-L4052	251,535.52	248,055.52	3,480.00
<b>МУЗГ-ын санхүүжилт</b>	<b>229,914,218.56</b>	<b>17,893,015.21</b>	<b>212,021,203.35</b>
CMP мөнгөн тусlamж НӨАТ-ын болон татварын чөлөөлөлт	229,810,371.49	17,789,168.14	212,021,203.35
	103,847.08	103,847.08	
<b>Бусад зардал</b>	50.00	25.00	25.00
Банкны шимтгэл	50.00	25.00	25.00
Валютын ханшийн алдагдал	-	-	-
<b>Нийт зарцуулалт</b>	<b>298,209,464.59</b>	<b>44,406,347.74</b>	<b>253,803,116.85</b>
<b>Цэвэр санхүүжилт/(зарцуулалт)</b>	<b>425,652.54</b>	<b>443,956.73</b>	<b>443,956.73</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>425,652.54</b>	

**2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН  
АУДИТЛАГДСАН ТӨСӨВ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Эх үүсвэр ба зардлын төрөл	Нийт санхүүжилтийн хуваарилагдсан Ам.доллар	Хуримтлагдсан 12/31/2022 Ам.доллар	Зарцуулалт		Хуримтлагдсан 12/31/2021 Ам.доллар	Зарцуулалт		
			Тайлант онд Ам.доллар	2022		2021	Нийт	
<b>АХБ-ны зээлийн эх үүсвэрээр санхүүжсэн- L4051-MON</b>								
A. Хөрөнгө оруулалтын зардал								
CMP мөнгөн тусламж	26,360,000.00	26,223,161.61	4,093,752.74	22,129,408.87	15.5%	84.0%	99.5%	
ХҮҮ	240,000.00	240,000.00	240,000.00	-	100.0%	-	100.0%	
<b>АХБ-ны зээлийн эх үүсвэрээр санхүүжсэн- L4052-MON</b>								
A. Хөрөнгө оруулалтын зардал								
CMP мөнгөн тусламж	41,770,000.00	40,559,250.42	20,945,269.06	19,613,981.36	50.1%	47.0%	97.1%	
Бараа	3,160,000.00	753,845.77	753,845.77	-	23.9%	-	23.9%	
Зөвлөх үйлчилгээ	420,000.00	105,972.75	105,972.75	-	25.2%	-	25.2%	
TXH-ийн үйл ажиллагааны зардал	240,000.00	108,068.41	108,068.41	-	45.0%	-	45.0%	
B. Болзошгүй зардал	300,000.00	-	-	-	0.0%	-	0.0%	
C. Хэрэгжүүлэх явцал гарах санхүүгийн төлбөр	510,000.00	251,535.52	248,055.52	3,480.00	48.6%	0.7%	49.3%	
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>								
A. Хөрөнгө оруулалтын зардал								
CMP мөнгөн тусламж	186,320,178.00	229,810,371.49	17,789,168.14	212,021,203.35	9.5%	114.1%	123.3%	
Бараа	319,822.00	103,847.08	103,847.08	-	32.5%	-	32.5%	
<b>Нийт</b>	<b>259,640,000.00</b>	<b>298,156,053.46</b>	<b>44,387,979.46</b>	<b>253,768,073.58</b>	<b>17.1%</b>	<b>97.9%</b>	<b>114.8%</b>	

**2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН  
АУДИТЛАГДСАН ТУСГАЙ ДАНСНЫ ТАЙЛАН**

	2022 ам.доллар	2021 ам.доллар
<b>Хэсэг А- Дансны хөдөлгөөн</b>		
<b>Эхний үлдэгдэл</b>	441,758.51	-
<b>Нэмэх нь:</b>		
Тайлант жилд хүлээн авсан мөнгө	-	-
АХБ-наас авсан урьдчилгаа	479,000.00	
Дэд данснаас орж ирсэн мөнгө	315,252.70	-
Хүүний орлого	-	-
<b>Хасах нь:</b>		
Төгрөгийн дэд дансруу шилжүүлсэн	-	-
Ам долларын дэд дансанд шилжүүлсэн	404,054.85	37,216.49
Бэлтгэн нийлүүлэгчид шилжүүлсэн төлбөр	-	-
Төслийн удирдлагын зардал	25.00	25.00
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<u>352,931.36</u>	<u>441,758.51</u>
<b>Хэсэг Б- Банкны тохируулга</b>		
<b>АХБ-ны урьдчилгааны дүн</b>	352,931.36	479,000.00
<b>Тусгай дансны тайлант жилийн үлдэгдэл</b>	126,132.73	441,758.51
<b>Нэмэх:</b>		
Зарцуулсан боловч нэхэмжлээгүй дүн	53,386.55	35,018.27
Нэхэмжилсэн боловч санхүүжүүлээгүй дүн	-	-
Долларын дэд дансны үлдэгдэл	-	-
Төгрөгийн дэд дансны үлдэгдэл	72,721.18	2,198.22
Тендертэй холбоотой зардал	-	-
Банкны шимтгэл	25.00	25.00
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	-
<b>Хасах:</b>		
Хүүний орлого	-	-
Тендерийн бичиг баримтын орлого	64.09	-
<b>Тусгай дансны нийт урьдчилгааны дүн</b>	<u>479,000.00</u>	<u>479,000.00</u>

**2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН  
АУДИТЛАГДСАН ДЭЛГЭРЭНГҮЙ ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН**

Хүсэлтийн дугаар	CMP мөнгөн тусlamж Ам.доллар	Бараа Ам.доллар	Зөвлөх үйлчилгээ Ам.доллар	Төслийн үйл ажиллагаа Ам.доллар	Нийт Ам.доллар
2021/12/31-аар хуримтлагдсан	41,743,390.23				
L4051					
WA#51003	4,093,752.74	-	-	-	4,093,752.74
L4052					
WA#52004	20,945,269.06				20,945,269.06
WA#52005		101,211.54	105,972.75	108,068.41	315,252.70
WA#52006		652,634.23			652,634.23
<b>Тайлант онд</b>	<b>25,039,021.80</b>	<b>753,845.77</b>	<b>105,972.75</b>	<b>108,068.41</b>	<b>26,006,908.73</b>
<b>Зарцуулалт</b>	<b>25,039,021.80</b>	<b>753,845.77</b>	<b>105,972.75</b>	<b>108,068.41</b>	<b>26,006,908.73</b>
<b>Зөрүү</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2022/12/31-аар хуримтлагдсан</b>	<b>66,782,412.03</b>	<b>753,845.77</b>	<b>105,972.75</b>	<b>108,068.41</b>	<b>67,750,298.96</b>

**2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ЭЦСИЙН  
АУДИТЛАГДСАН ТУСГАЙ ДАНСНЫ НӨХӨН ДҮҮРГЭЛТИЙН ТАЙЛАН**

Нөхөн дүүргэлтийн дугаар	Санхүүжилтийн төрөл	Нэхэмжилсэн дүн Ам.доллар	Санхүүжүүлсэн дүн Ам.доллар	Зөрүү Ам.доллар
	2021/12/31-аар хуримтлагдсан	41,743,390.23	41,743,390.23	-
WA#51003	Нөхөн төлбөр	4,093,752.74	4,093,752.74	-
WA#52004	Нөхөн төлбөр	20,945,269.06	20,945,269.06	-
WA#52005	Нөхөн дүүргэлт	315,252.70	315,252.70	-
WA#52006	Шууд төлөлт	652,634.23	652,634.23	-
<b>Тайлант онд нийт</b>		<b>26,006,908.73</b>	<b>26,006,908.73</b>	<b>-</b>
<b>2022/12/31-аар хуримтлагдсан</b>		<b>66,782,412.03</b>	<b>66,782,412.03</b>	<b>-</b>

# ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

12 САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН 2022 ОН

## 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн өрөнхий мэдээлэл:

Монгол Улсын Засгийн Газар (ЗГ), Азийн Хөгжлийн Банк (АХБ) хооронд 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрээр “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2”-ийг хэрэгжүүлэхэд АХБ-ны ердийн хөрөнгийн эх үүсвэр (ЕХЭҮ)-ээс санхүүжигдэх 46,400,000.00 ам.долларын ердийн зээл 4052-МОН, 26,600,000.00 ам.долларын хөнгөлөлттэй зээл 4051-МОН дугаартай зээлүүдийг олгохоор болсон. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 5-р сарын 10-ны өдөр тус зээлийг соёрхон баталсан. Төсөл хэрэгжиж дүусах хугацаа 2023 оны 12 дугаар сарын 31 байна.

### Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын зорилго:

Төслийн гол зорилго нь цар тахлын үед ядуу, эмзэг бүлгийн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдэд нийгмийн халамжийн дэмжлэгийг сайжруулна.

### 1.2 Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын бүрэлдэхүүн хэсэг

Уг төсөл нь дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- 2021 оны 01 дүгээр сараас 6 дугаар сар хүртэл 6 сарын хугацаанд цар тахлын хариу арга хэмжээний хүрээнд нэмэлтээр сар бүр олгох хүүхдийн тэтгэмжийн нэмэлт хувийг санхүүжүүлэх;
- Ирээдүйд гарах хямралд өрхийн даван туулах чадвар болон засгийн газрын хариу арга хэмжээг сайжруулахын тулд дараах гурван чиглэлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх юм.
  - Орлого орлуулан тооцох аргачлалаар хийх дараагийн судалгааг шинэ аргачлалаар явуулахад дэмжлэг үзүүлэх замаар бодит хэрэгцээтэй иргэдэд хүрч үйлчлэх үүднээс ядуу зорилтолт бүлгийг тогтоох систем болон өрхийн мэдээллийн нэгдсэн санг илүү нарийвчилсан өгөгдлөөр шинэчлэх
  - Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг “ehalamj” системд холбож, тэтгэмж, үйлчилгээ үзүүлэх ажлыг шуурхай болгох
  - Төгсөлтийн аргачлалын амьжиргааг сайжруулж, чадваржуулахад чиглэсэн цогц арга хэмжээ бүхий бэлэн мөнгөн тэтгэмж дээр сууриссан нийгмийн хамгааллын шинэлэг хөтөлбөр болгон туршиж үнэлгээ хийх

Төслийн нийт санхүүжилтийн төлөвлөгөө дараах байдалтай байна.

	АХБ Сая ам.доллар	Засгийн Газар Сая ам.доллар	Нийт Сая ам.доллар
<b>A. Хөрөнгө оруулалтын зардал</b>			
1.Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн мөнгөн тэтгэмж	68.13	186.32	254.45
2.Бараа, үйлчилгээ	3.16	0.32	3.48
3.Зөвлөх үйлчилгээ	0.42	0.00	0.42
4.Төслийн удирдлага	0.24	0.00	0.24
<b>Дэд нийлбэр (A)</b>	<b>71.95</b>	<b>186.64</b>	<b>258.59</b>
<b>B. Магадалшгүй</b>			
1.Биет	0.15	0.00	0.15
2.Үнийн	0.15	0.00	0.15
<b>Дэд нийлбэр (B)</b>	<b>0.30</b>	<b>0.00</b>	<b>0.30</b>
<b>C. Хэрэгжүүлэх явцын санхүүгийн төлбөр</b>			
<b>Төслийн нийт зардал (A + B + C)</b>	<b>73.00</b>	<b>186.64</b>	<b>259.64</b>

## **ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2**

### **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

**12 САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН 2022 ОН**

**1.3 Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2 нь тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:**

1. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нэмэгдлийг олгох; Төслийн хүрээнд Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн 2021 оны 12 дугаар сарын нөхөн санхүүжилтэд 82.7 тэрбум төгрөгийг 2022 оны 9 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд АХБ-аас нөхөн дүүргэлт хэлбэрээр Сангийн яамны Монгол банкин дахь төгрөгийн дансанд төвлөрүүлсэн байна.
2. Нийгмийн халамжийн хөтөлбөр, тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; Орлого орлуулан тооцох аргачлалыг ашиглан дахин баталгаажуулах судалгаа хийхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд худалдан авалтын төлөвлөгөөнд туссан C001: ООТА-ын олон улсын зөвлөх, C002: ООТА-ын дотоодын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - Хүрэх үр дүн 1: ООТА-аар өрхийн амьжирааны түвшин тодорхойлох судалгаанд дэмжлэг үзүүлэх, аргачлал, томъёоны талаар зөвлөгөө өгөх, судалгаанд шинжилгээ хийх;
3. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг "ehalamj" системд холбож, тэтгэмж, үйлчилгээ үзүүлэх ажлыг шуурхай болгох; Нийгмийн халамжийн цахим системийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд нийт 10 багцаар (C003, C004, C005, C006, C007, C008, C009, C011, C012, G001) хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:
  - Хүрэх үр дүн 1: (C003, C009, C011) Шинэчилсэн ООТА-ын дагуу өрхийн мэдээллийн сантай холбоотой системийн хөгжүүлэлт хийх, судалгааны явцад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах;
  - Хүрэх үр дүн 2: (C006, C012, C004, C005): Системийн шинжилгээ хийх, бизнес процесс боловсруулах, ehalamj системийн хөгжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх;
  - Хүрэх үр дүн 3: (C007, C008) Бизнесийн ухаалаг системийн сайжруулалтыг гүйцэтгэх, шаардлагатай өөрчлөлтийн дагуу хөгжүүлэлт, тохиргоо хийх;
4. Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах; Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд нийт 3 багцыг (C010, C013, C014) хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:
  - Хүрэх үр дүн 1: (C010) Төгсөлтийн аргачлал туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;
  - Хүрэх үр дүн 2: (C013) Зах зээлийн судалгаа хийх байгууллагын сонгон шалгаруулах;
  - Хүрэх үр дүн 3: (C014) Хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны байгууллага сонгон шалгаруулах.
5. Худалдан авалтын төлөвлөгөө хэрэгжилтийн хүрээнд нийт 3,111,500 ам.дол. бүхий бараа үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ, хувь зөвлөх гэсэн 3-н багц төрлөөр нийт 15-н ажилд тендер шалгаруулж 2,751,965 ам.дол гэрээ байгуулж ажилласан байна.

Төслийн хэрэгжилтийн явц 2022 оны 12-р сарын байдлаар Төслийн нийт хэрэгжилтийн явц 49.3%, 1-р бүрэлдэхүүн хэсгийн явц 100%, 2-р бүрэлдэхүүн хэсгийн явц 40.2% байна.

## ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

12 САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН 2022 ОН

### 1.4 Төслийн удирдах хороо /Төсөл удирдах нэгж/

Төслийн Удирдах Хороог ХНХ-ын Сайдын 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн А/129 дугаар тушаалаар байгуулсан. Тайлант хугацаанд уг Хорооны 3 удаагийн хурлыг зохион байгуулав. ТУХ-ын 3 дахь хурлыг 2022 оны 01 дүгээр сарын 18-ний өдөр зохион байгуулж, нийт төслийн хүрээний үйл ажиллагааны төлөвлөгөө зээлийн зарцуулалт болон дахин хувиарлалт хийх талаар хэлэлцэн байна. 4 дэхь хурлыг 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан бөгөөд ТХН-ийн ажилтнуудын Хөлсөөр ажиллах гэрээний биелэлтийн үнэлгээг танилцуулж, зөвлөмж гаргасан байна. 5 дахь хурлыг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж НӨАТ-с татвараас чөлөөлүүлэх барааны жасгаалтыг гаргаж хавсралтаар хэлэлцэж баталсан байна.

Төслийн Удирдах Хороо дараах бүрэлдэхүүнтэй байна.

№	Бүрэлдэхүүн	Албан тушаал
1	Төслийн удирдах хорооны дарга	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга
2	Төслийн удирдах хорооны гишүүн	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга
3	Төслийн удирдах хорооны гишүүн	Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга
4	Төслийн удирдах хорооны гишүүн	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
5	Төслийн удирдах хорооны гишүүн	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
6	Төслийн удирдах хорооны гишүүн	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга
7	Төслийн удирдах хорооны гишүүн	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэдээлэл технологи, статистикийн хэлтсийн дарга
8	Төслийн удирдах хорооны гишүүн	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
9	Төслийн удирдах хорооны гишүүн	Азийн хөгжлийн банкны Монгол улс дахь Суурин төлөөлөгчийн газрын ахлах мэргэжилтэн
10	Төслийн удирдах хорооны нарийн бичгийн дарга	ТХН Төслийн Зохицуулагч

### 1.5 Төсөл хэрэгжүүлэх нэгж

АХБ, Монгол Улсын Засгийн газрын хооронд зээлийн гэрээ байгуулж, 2021 оны 6 дугаар сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсноор Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоо, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг Сангийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 106 дугаар тушаалаар батлуулсан. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтан тус бүр Хөлсөөр ажиллах 2022 оны гэрээг ХНХЯ, СЯ-тай зохих журмын дагуу байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардлын дэд данснаас хийгдэх санхүүжилтийн төсвийг улирал бүр бэлтгэн ХНХЯ болон СЯ-аар хянуулан батлуулж, батлагдсан төсөвт багтаан зарцуулалтыг хийж байна.

# ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

12 САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН 2022 ОН

---

### 2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд

#### a) **Тайлангийн бүрэлдэхүүн**

Төслийн санхүүгийн тайлан нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

1. Санхүүгийн байдлын тайлан
2. Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан
3. Өмчийн өөрчлөлтийн тайлан
4. Тусгай дансны мөнгөн гүйлгээний тайлан
5. Тусгай дансны нөхөн дүүргэлтийн тайлан
6. Зарцуулалтын тайлан

#### b) **Тайлан бэлтгэсэн үндэслэл**

Төслийн санхүүгийн тайланг УСНББОУС-ын стандартад нийцүүлэн Азийн хөгжлийн банкны

Төслийн удирдлагын гарын авлага, Зээлийн гэрээний санхүү нягтлан бодох бүртгэлийн заалтуудыг мөрдөж гаргана.

#### c) **Тайлангийн хэмжилт**

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт зээлийн гэрээнд заасан валют болох ам.доллараар тайлагнасан. Ам.доллараас бусад валютаар илэрхийлсэн мөнгөн зүйлсийн үлдэгдлийг ам.доллараар илэрхийлэхдээ тайлангийн тасалбар болгосон өдрийн Монгол банкны албан ханшийг, мөнгөн бус зүйлсийн хувьд түүхэн ханш ашигласан. Төгрөгөөр хийгдсэн гүйлгээг ам долларыг шилжүүлэхдээ үйл ажиллагааны дансанд зузаатгалын зорилгоор арилжаа хийгдсэн ханшаар тухайн зузаатгал дуусах хүртэл шилжүүлэн тооцож бүртгэнэ. Ханшийн зөрүүнээс үүссэн ашиг алдагдлыг санхүүгийн үр дүнгийн тайланда тусгана.

#### d) **Тайлангийн толилуулга**

Төслийн санхүүгийн тайланг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн үлдэгдлийг эхний үлдэгдэл болгон 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон дансдын үлдэгдлийг өссөн дүнгээр илэрхийлнэ.

#### e) **Тайланг хянах байгууллага**

Азийн хөгжлийн банк, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний Аудитын газар

#### f) **Бүртгэл мэдээллийн систем**

Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандaa Acolous программ хангамж ашигладаг.

#### g) **Орлого**

Азийн хөгжлийн банкны санхүүжилт болон Засгийн газрын татварын чөлөөлөлтийг аккурэл сууриар бүртгэнэ. Мөн дансны хүүний орлого, тендерийн орлогыг бүртгэнэ.

#### h) **Зардал**

Зарцуулалтыг зориулалтын дагуу аккурэл сууриар бүртгэнэ.

#### i) **Тусгай данс**

Зээлийн тусгай дансыг Азийн хөгжлийн банкны зөвшөөрлөөр Төрийн сан болон Төрийн банкинд байршдаг.

## ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

12 САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН 2022 ОН

#### j) *Татвар*

Нэмэгдсэн өртгийн албан татварын 13 дугаар зүйлийн 13.1.3-т "гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусlamж, хөнгөлөлттэй зээлээр авсан бараа" татвараас чөлөөлөхийг тодорхойлсон. Жил бүр Сангийн сайдын тогтоолоор зээл, тусlamжийн төслөөр нийлүүлж буй бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвар, онцгой албан татвараас чөлөөлөхөөр заасан.

#### k) *Бараа болон зөвлөх бус үйлчилгээний худалдан авалт*

ТХН нь хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч байгууллагуудын нэрийн өмнөөс төслийн хүрээнд худалдан авах ажиллагааг хариуцах болно. Худалдан авалт нь АХБ-ны Худалдан авах ажиллагааны бодлого (2017 онд батлагдсан, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийн хамт), АХБ-ны зээлдэгчдэд зориулсан Худалдан авах ажиллагааны журам (2017 онд батлагдсан, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийн хамт)-ын дагуу явагдана.

АХБ-наас өөрөөр тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд бараа, зөвлөх бус үйлчилгээний худалдан авахад доорх аргуудыг хэрэглэнэ.

#### Арга

Бараанд шууд гэрээлэх

#### Тайлбар

Мэдээллийн сангийн програм хангамж худалдан авах;  
урьдчилсан хяналт

Бараанд нээлттэй өрсөлдөөнт тендер  
шалгаруулалт

Дотоодын зар; урьдчилсан хяналт

Барааны үнийн санал авах хүсэлт  
Зөвлөхийн бус үйлчилгээнд үнийн  
санал авах хүсэлт

Дараа хяналт

Анхны гэрээнд урьдчилсан хяналт тавина; дараагийн  
гэрээнүүдэд дараа хяналт тавина

Шүүд гэрээ байгуулах, дотоодод зарлах нээлттэй өрсөлдөөнт тендер шалгаруулалт (НӨТШ), үнийн санал авах хүсэлт (ҮСХ)-ийн журмыг бараа, зөвлөхгүй үйлчилгээ худалдан авахад ашиглана. Нийгмийн халамжийн хөтөлбөрийг цахимжуулахад дэмжлэг үзүүлэх мэдээллийн сангийн програм хангамж, техник хангамжийг худалдан авахад шууд гэрээ байгуулна. Засгийн газрын Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн хүлээсэн чиг үүргийн дагуу бусад яамдад ашигладаг Oracle мэдээллийн сангийн системтэй нийцтэй байдлыг хангах үүднээс мэдээллийн сангийн системийг АНУ-ын Oracle корпорациас шууд худалдан авах болно. Дотоодод зарлах НӨТШ-ийг төгсөлтийн туршилтын хөтөлбөрийн хүрээнд ядуу иргэдэд амьжираагаа сайжруулах жижиг тоног төхөөрөмж худалдан авахад ашиглах болно. ҮСХ журмыг төгсөлтийн туршилтын хөтөлбөрт зориулан (i) зах зээлийн судалгааны үйлчилгээ, мөн (ii) хэвлэл мэдээллийн үйлчилгээг худалдан авахад ашиглах болно.

#### l) *Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт*

Худалдан авалт нь АХБ-ны Худалдан авах ажиллагааны бодлого (2017 онд батлагдсан, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийн хамт), АХБ-ны зээлдэгчдэд зориулсан Худалдан авах ажиллагааны журам (2017 онд батлагдсан, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийн хамт)-ын дагуу явагдана. АХБ-наас өөрөөр тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд зөвлөх үйлчилгээний худалдан авахад доорх аргуудыг хэрэглэнэ.

#### Арга

Чанарт сууринсан сонгон шалгаруулалт

#### Тайлбар

Хялбарчилсан техникийн санал;  
урьдчилсан хяналт

Зөвлөхийн мэргэжлийн чадварт сууринсан  
сонгон шалгаруулалт

Биодата техникийн санал; урьдчилсан  
хяналт

Хувь зөвлөх сонгон шалгаруулалт

Урьдчилсан хяналт

**ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

**12 САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН 2022 ОН**

**3. Мөнгө ба мөнгтэй адилтгах хөрөнгө**

	2022 ам.доллар	2021 ам.доллар
Тусгай данс	-	-
Дэд данс	425,652.54	443,956.73
	<b>425,652.54</b>	<b>443,956.73</b>

Мөнгө ба мөнгтэй адилтгах хөрөнгө дансанд Тусгай дансны ам долларын данс ба дэд дансны төгрөгийн дансны гүйлгээ хамаарна. Тусгай дансанд АХБ-ны санхүүжилтийг татан авч төлөвлөрүүлэн дэд дансруу шилжүүлж үйл ажиллагааны болон бусад холбогдох зардлыг төлдөг.

**4. Авлагын төлөвлөрүүлэлт**

	2022 ам.доллар	2021 ам.доллар
Ажилчдаас авах авлага	50.22	19.66
	<b>50.22</b>	<b>19.66</b>

**5. Урьдчилгаа**

	2022 ам.доллар	2021 ам.доллар
Урьдчилгаа	753,845.77	-
	<b>753,845.77</b>	<b>-</b>

**6. Бараа материал**

	2022 ам.доллар	2021 ам.доллар
Хангамжийн материал	676.54	231.52
	<b>676.54</b>	<b>231.52</b>

**7. Өглөг**

	2022 ам.доллар	2021 ам.доллар
Цалингийн өглөг	31.11	8.42
ХХОАТ-ын өглөг	-	11.24
	<b>31.11</b>	<b>19.66</b>

**8. Урт хугацаат өр төлбөр**

	2022 ам.доллар	2021 ам.доллар
Урт хугацаат зээл	68,720,834.48	42,225,870.23
	<b>68,720,834.48</b>	<b>42,225,870.23</b>

2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн Зээлийн хэлэлцээрийн дагуу АХБ-наас Монгол Улсын Засгийн газарт 73.0 сая ам. доллартай тэнцэх хэмжээний мөнгө зээлэхийг зөвшөөрсөн бөгөөд зээлийн эргэн төлөлт 2026 оны 8 дугаар сарын 15-наас эхэлнэ. Тайлант хугацаанд АХБ-наас 26,494,964.25 ам.долларын санхүүжилт олгосон байна.

**ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**

**12 САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН 2022 ОН**

**9. Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн мөнгөн тэтгэмж**

	2022 ам.доллар	2021 ам.доллар
ХМХ-ийн мөнгөн тэтгэмж	25,039,021.80	41,743,390.23
	<u>25,039,021.80</u>	<u>41,743,390.23</u>

**10. Бараа**

	2022 USD	2021 USD
Бараа	103,847.08	-
	<u>103,847.08</u>	<u>-</u>

Төсөл нь мэдээллийн сангийн сервер, холбогдох тоног төхөөрөмж нийлүүлэх худалдан авах ажиллагааны хүрээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, Ай Ти Зон ХХК-тай 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр гэрээ байгуулсан байна. Үүнтэй холбоотой гарсан НӨАТ болон гаалийн татварын чөлөөлөлтийн хэсэг үүнд орсон байна.

**11. Зөвлөх үйлчилгээ**

	2022 USD	2021 USD
Зөвлөх үйлчилгээ – Монголын улаан загалмай нийгэмлэг	117,387.46	-
Зөвлөх үйлчилгээ – Хувь хүн	37,582.12	-
	<u>154,969.58</u>	<u>-</u>

Зөвлөх үйлчилгээний нийт зардлын 76 хувийг Монголын улаан загалмай нийгэмлэгээс бүрдэж байна. Тус төсөл МУЗН-тэй Төгсөлтийн туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан. Энэхүү хөтөлбөр нь COVID-19 цар тахлын нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах, ялангуяа хүн амын ядуу, эмзэг бүлэгт үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилготой юм.

**12. Төслийн удирдлага**

	2022 ам.доллар	2021 ам.доллар
ТХН-ийн ажилчдын цалин	56,771.74	28,556.01
НДШ-ын зардал	7,058.60	3,570.21
	<u>63,830.34</u>	<u>32,126.22</u>

**13. Урсгал зардал**

	2022 ам.доллар	2021 ам.доллар
Бичиг хэргийн зардал	550.86	529.09
Шатахуун, сэлбэг хэрэгсэл	263.20	351.06
Шуудан холбооны зардал	1,159.75	441.85
Хангамжийн зардал	51.76	-
Засварын зардал	0.00	63.19
Зар суртацилгааны зардал	1,386.78	449.26
Бусад цалингийн зардал	3,273.80	737.25
Бусад зардал	76.10	88.83
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	6,357.21	-
	<u>13,119.46</u>	<u>2,660.53</u>

**ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2****САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД****12 САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН 2022 ОН****14. Санхүүгийн зардал**

	2022 ам.доллар	2021 ам.доллар
Хүү амлалтын шимтгэл	488,055.52	3,480.00
	<u>488,055.52</u>	<u>3,480.00</u>

**15. Банкны шимтгэл**

	2022 ам.доллар	2021 ам.доллар
Дамжуулагч банкны шимтгэл	25.00	25.00
Банкны шимтгэл	-	-
	<u>25.00</u>	<u>25.00</u>

**16. Тайлангийн дараах үйл явдал**

Тайлант хугацааны дараа тохируулах болон тохируулахгүй, санхүүгийн тайланд нөлөөлөхүйц үйл явдал гараагүй байна.

Тайлангийн хугацаанаас хойшхи энэ үйл явдал нь УСНББОУС 14-т заасны дагуу төслийн нэгж нь үл залруулагдах тайлангийн дараах үеийн үйл явдал гэж тогтоожээ. Иймд, 2022 оны 12-р сарын 31-ний өдөр болон тухайн жилийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг тэдгээрийн нөлөөллийг тусгахаар тохируулаагүй болно.

**17. Монгол хэл дээрх орчуулга**

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувилбаруудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувийг дагана.



THE GLOBAL ADVISORY  
AND ACCOUNTING NETWORK

Suite 505 505a, Munkh Tower office 39,  
Chinggis avenue, 19th khoroolol 17030,  
1st khoroo, Khan-Uul district,  
Ulaanbaatar, Mongolia

**TEL:** 1 326275

**EMAIL:** [info@hlb.mn](mailto:info@hlb.mn)

**WEB:** [www.hlb.global](http://www.hlb.global)